



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/69

Хатан суудал

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хатансуудал 5 дугаар багийн нутаг "Арын ус" хэмээх газарт Завхан аймгийн "Их-Уул", "Отгон" сумдаас малчин П.Норов 280 тооны ямаа тээвэрлэн ирсэн тул тухайн нутаг дэвсгэрт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл хязгаарлалтын дэглэм тогтоосугай.


2.Мал, хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлт, мал сүрэгт тогтмол үзлэг хийхийг "Хар ботго" мал эмнэлгийн Малын эмч (Г.Ерөөлт)-д үүрэг болгосугай.

3.Тухайн нутаг дэвсгэрийн малын шилжилт хөдөлгөөн, хязгаарлалтын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Хатансуудал 5 дугаар багийн Засаг дарга (Б.Амаржаргал), Мал эмнэлгийн улсын байцаагч (Н.Цэрэндолгор) нарт хариуцуулсугай.

4.Тус нутаг дэвсгэр, айл өрхөд хүрч ажиллах хүн хүч, бензин шатахууныг шийдвэрлэн удирдлагаар хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642201061